2016-2018 онуудад нүдний кабинетаар үйлчлүүлэгчдийн өвчлөлийн хөдлөл зүйд хийсэн судалгаа

Д.Батжаргал[1], Ш.Мягмарсүрэн[2]

[1]Поликлиникийн тасаг, УХТЭ
[2]СДМТА-ийн дарга, УХТЭ
Цахим хаяг: mrdbatjargal@gmail.com

Түлхүүр үгс:

Нүдний өвчлөл
Болор цайх эмгэг
Нүдний даралт ихсэх өвчин
Хараа муудах

Товч утга: Энэхүү судалгааг хийх болсон шалтгаан нь хүн амын дунд нүдний өвчлөлийн талаар судалгаа дутагдалтай, нүдний эмчилгээний хүртээмжийг сайжруулах талаар судалгаа хийгдээгүй явдал юм. Бид 2016-2018 оны поликлиникийн нүдний кабинетийн тайлан, өвчний тайланг ашигласан болно. Үр дүнгээс харахад катаракт нь хамгийн их тохиолдох 5 өвчний нэгдүгээрт, глауком нь давхар сохролын гол шалтгаануудын 3-р байранд ордог байна. Өвчлөлийн хөдлөл зүйн хувьд, нүдний хугарлын өөрчлөлт 30-44, линз, салст бүрхэвчийн эмгэг, глаукома нь 40-59 наснаас нэмэгдэж эхэлдэг байна. Катаракт мэс заслын олон улсын стандарт эмчилгээг нэвтрүүлэх, глауком өвчнөөс урьдчилан сэргийлэх шинэ кабинет байгуулах, харьцангуй залуу насанд тохиолддог хугарлын алдаанаас үүссэн харааны алдагдлыг засах харааны тусламж үйлчилгээг үзүүлэх арга хэмжээг эхлүүлэх шаардлагатай гэж бид дүгнэв. Эдгээр асуудлыг цогцоор нь шийдвэрлэх зорилгоор Улсын хоёрдугаар төв эмнэлэгт Нүдний эрүүл мэндийн төв байгуулах төслийг яаралтай эхлүүлэх шаардлагатай байна.

Үндэслэл: Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр[1] болон Зайлсхийж болох сохрол, хараа сулралаас сэргийлэх, хянах стратегид[2] эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд жигд хүртээмжтэй хүргэхийн тулд статистик мэдээлэл, тандалтын талаархи эрдэм шинжилгээ судалгааны ажлыг эрчимжүүлэхээр тусгагдсан байдаг ба хүн амын нүдний өвчлөлийн байдлыг судлан, тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад чиглэгдсэн судалгаа бага байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо.

Зорилго: УХТЭ-ийн поликлиникийн тасгийн нүдний кабинетаар үйлчилүүлэгчдийн нүдний өвчлөлийн хөдлөл зүйд үнэлгээ хийх

Зорилт:

1. Нүдний кабинетаар үйлчлүүлэгчдийн нүдний өвчлөлийн бүтцийг судлах
2. 2016 – 2018 оны нүдний өвчлөлийн хөдлөл зүйг гарган бусад адил түвшний эмнэлэгүүдийн үзүүлэлтүүдтэй харьцуулан судлах
3. Нотолгоонд суурилсан нүдний нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг тодорхойлох

Хэрэглэгдэхүүн ба арга аргачлал: Бид судалгааг УХТЭ-ийн поликлиникийн тасгийн нүдний кабинетын 2016-2018 оны халдварт бус өвчлөлийг бүртгэх хуудсуудыг ашиглан дескриптив аргаар хийв. Судалгаанд хамрагдсан 12271 хүний мэдээллийг нэгтгэн SPSS-26 программаар үр дүнгийн боловсруулалт хийв. Судалгааны үр дүнг УНТЭ, УГТЭ-үүдийн 1998-2007 оны үйл ажиллагааны тайлангийн үзүүлэлттэй харьцууллаа.

Үр дүн: УХТЭ-ийн поликлиникийн тасгийн нүдний кабинетаар 2016-2018 онуудад нийт 12271 хүн үйлчлүүлснээс 2935/23,9%/ эрэгтэй% 9336/76,1%/ эмэгтэйчүүд байв.

Хүснэгт 1. Нүдний кабинетаар үйлчлүүлэгчдийн хүйсний байдал /P<0.005/

	2016	%	2017	%	2018	%	Бүгд
ЭР	829	26.6	1122	23.9	984	22.1	2935
ЭМ	2290	73.4	3582	76.1	3464	77.9	9336
Нийт	3119	100%	4704	100%	4448	100%	12271

Энэхүү үзүүлэлтээр жил бүр эмэгтэйчүүдийн нүдний өвчлөлийн тохиолдлын тоо ихсэж байна. Хүйсийн хамаарал 2016-2017 ба 2017-2018 оны тухайд P<0.05 байв.

Хүснэгт 2. Нүдний кабинетаар үйлчлүүлэгчдийн насны бүтэц /P<0.005/

Нас	2016	%	2017	%	2018	%	НИЙТ
0-14	0	0.0	0	0.0	37	0.8	37
15-29	73	2.3	94	2.0	118	2.7	285
30-44	179	5.7	263	5.6	228	5.1	670
45-59	848	27.2	1338	28.4	1220	27.4	3406
60-74	**1536**	**49.2**	**2168**	**46.1**	**2036**	**45.8**	**5740**
75+	483	15.5	841	17.9	809	18.2	2133
НИЙТ	3119	100%	4704	100%	4448	100%	12271

2016-2017 ба 2017-2018 оны тухайд P<0.05 байгааг насны бүлгийн өөрчлөлт ба оношийн хамаарлыг регрессийн шинжилгээгээр шалгахад ICD 10 = 0.03*gen+0.07*age+0.005*region+0.34 *year+78 гэсэн хамааралд нөлөөлөл P<0.005 байлаа. Иймээс насны өөрчлөлт нь өвчлөлийн хөдлөл зүйд нөлөөлсөн байна.

Хүснэгт 3. 2016-2018 онд тус кабинетаар үйлчлүүлэгчдийн х арьяаллын байдал /P<0.005/

	2016	%	2017	%	2018	%	Бүгд
Архангай	37	1.2	72	1.5	81	1.8	190
Баян-Өлгий	5	0.2	17	0.4	16	0.4	38
Баянхонгор	12	0.4	27	0.6	39	0.9	78
Булган	26	0.8	36	0.8	47	1.1	109
Говь-Алтай	10	0.3	23	0.5	35	0.8	68
Дорноговь	8	0.3	27	0.6	21	0.5	56
Дорнод	20	0.6	27	0.6	45	1.0	92
Дундговь	13	0.4	35	0.7	38	0.9	86
Завхан	31	1.0	60	1.3	68	1.5	159
Өвөрхангай	11	0.4	37	0.8	40	0.9	88
Өмнөговь	16	0.5	18	0.4	16	0.4	50
Сүхбаатар	25	0.8	46	1.0	41	0.9	112
Сэлэнгэ	31	1.0	59	1.3	69	1.6	159
Төв	48	1.5	97	2.1	108	2.4	253
Увс	18	0.6	20	0.4	39	0.9	77
Ховд	15	0.5	22	0.5	16	0.4	53
Хөвсгөл	16	0.5	58	1.2	67	1.5	141
Хэнтий	42	1.3	78	1.7	75	1.7	195
Дархан-уул	35	1.1	53	1.1	49	1.1	137
Улаанбаатар	**2667**	**85.5**	**3830**	**81.4**	**3477**	**78.2**	**9974**
Орхон	27	0.9	52	1.1	46	1.0	125
Говьсүмбэр	6	0.2	10	0.2	15	0.3	31
НИЙТ	3119	100%	4704	100%	4448	100%	12271


Дээрх үр дүнгээс харахад хүйс, нас, харьялал жил бүр /P<0.05/ өөрчлөгдөж байна. Мөн Улаанбаатар хотын иргэд 78,2-85,5%-иар голлох байрыг эзлэж байна.

Хүснэгт 4. Нүдний кабинетаар үйлчлүүлэгчдийн өвчлөлийн бүтэц /P<0.005/

	2016	%	2017	%	2018	%	Бүгд
Other disorders of eye and adnexa	0	0.0	1	0.0	0	0.0	1
Disorders of optic nerve and visual pathways	2	0.1	4	0.1	0	0.0	6
Visual disturbances and blindness	2	0.1	26	0.6	36	0.8	64
Disorders of sclera, cornea, iris and ciliary body	31	1.0	26	0.6	27	0.6	84
Disorders of vitreous body and globe	1	0.0	38	0.8	51	1.1	90
Disorders of choroid and retina	216	6.9	39	0.8	11	0.2	266
Disorders of eyelid, lacrimal system and orbit	165	5.3	230	4.9	316	7.1	711
Disorders of conjunctiva	166	5.3	376	8.0	613	13.8	1155
Glaucoma	308	9.9	459	9.8	430	9.7	1197

Disorders of ocular muscles, binocular movement, accommodation and refraction	875	28.1	1340	28.5	924	20.8	3139
Disorders of lens	1353	43.4	2165	46.0	2040	45.9	5558
Нийт	3119	100%	4704	100%	4448	100%	12271

Өвчлөлийн бүтцийг оношийн бүлгээр нь харьцуулахад 2016-2017 ба 2017-2018 оны тухайд P<0.05 байсан байна.



Хүснэгт 5. Нүдний кабинетаар үйлчлүүлэгчдийн өвчний оношболон насны хамаарал /P<0.005/

	0-14	15-29	30-44	40-59	60-74	75+
Other disorders of eye and adnexa	0	0	0	0	1	0
Disorders of optic nerve and visual pathways	0	1	0	2	3	0
Visual disturbances and blindness	1	11	16	16	12	8
Disorders of sclera, cornea, iris and ciliary body	0	6	5	15	43	15
Disorders of vitreous body and globe	0	1	0	21	51	17
Disorders of choroid and retina	0	5	12	71	138	40
Disorders of eyelid, lacrimal system and orbit	18	73	100	173	274	73
Disorders of conjunctiva	6	57	116	**381**	**492**	103
Glaucoma	0	2	33	**343**	**606**	213
Disorders of ocular muscles, binocular movement, accommodation and refraction	12	126	**377**	**1790**	**792**	42
Disorders of lens	0	3	11	**594**	**3328**	**1622**

30-34 наснаас эхлэн нүдний хугарлын эмгэг нэмэгдэж байгаа ба 40-59 насанд глаукомын тохиолдол ихсэж улмаар 60-74 насанд Болорын цайралт их байна. Нийт өвчлөлийн 65 хувь нь шинэ байсан ба 35 хувь нь хуучин өвчлөл байлаа.

Хүснэгт 6. 2016-2018 онд тус кабинетаар үйлчлүүлэгчдийн шинэ/хуучин өвчлөл /P<0.005/

	Шинэ	Хуучин	Өөрчлөлт
Other disorders of eye and adnexa	1	0	
Disorders of optic nerve and visual pathways	3	3	1.0
Visual disturbances and blindness	42	22	1.9
Disorders of sclera, cornea, iris and ciliary body	41	43	1.0
Disorders of vitreous body and globe	**72**	**18**	**4.0**
Disorders of choroid and retina	49	217	0.2
Disorders of eyelid, lacrimal system and orbit	502	209	2.4
Disorders of conjunctiva	917	238	3.9
Glaucoma	672	525	1.3
Disorders of ocular muscles, binocular movement, accommodation and refraction	2283	856	2.7
Disorders of lens	3427	2131	1.6

Энэхүү хүснэгтээс харахад шилэнцэр болон салстын эмгэгүүдийн хуучин тохиолдолууд илүү байна.

Хэлцэмж: УХТЭ-ийн нүдний кабинетаар үйлчлүүлэгсдийн нас, хүйс, харьяалалыг УНТЭ болон УГТЭ–ийн судалгаануудтай харьцуулахад насны хувьд харьцангуй ижил (60-аас дээш), хүйсийн хувьд УХТЭ–д эмэгтэйчүүд, харьяаллын хувьд Улаанбаатар хотын иргэд илүү хандсан бол харин УНТЭ, УГТЭ-д энэхүү үзүүлэлтүүд ялгаа багатай байлаа.

Өвчлөлийн бүтцийн хувьд УХТЭ-д болорын эмгэг болон хугарлын гажиг, глаукомын улмаас илүү хандсан бол УНТЭ-д болорын (28%) болон глаукомын (20%) улмаас илүү хандсан байна.

Дүгнэлт:

1. УХТЭ-ийн нүдний кабинетаар 2016-2018 онуудад үйлчлүүлэгсдийн өвчлөлийн хөдлөл зүй болон бүтцээс харахад тэргүүлэх 5 өвчлөлд болорын эмгэг (5558) илүү тохиолдож байна.
2. Хоёр нүдний сохролын гол шалтгаан болох глаукомын (1197) тохиолдол 3-р байранд байна.
3. Өвчлөлийн тохиолдолын хувьд 30-44 наснаас рефракцын эмгэг, 40-59 наснаас болорын болон глауком, салстын эмгэгүүд ихсэж байв.

Зөвлөмж:

1. Эмчлэгдэж болох хараа сулрал ба сохролын гол шалтгаан болох катарактын мэс заслын олон улсын стандарт эмчилгээг УХТЭ-д нутагшуулах
2. Эргэшгүй сохролд хүргэх гол шалтгаан болох глаукомын урьдчилан сэргийлэх, оношилгоо эмчилгээний шинэ кабинет байгуулах.
3. Харьцангуй залуу наснаас эхлэн тохиолдож байгаа рефракцийн гажигаас үүдэлтэй хараа сулралыг засах Хараа Зүйн тусламж үйлчилгээг эхлүүлэх шаардлагатай байна.
4. Эдгээр арга хэмжээнүүдийг иж бүрнээр нь шийдэх УХТЭ-ийн НҮДНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ-ийг байгуулах төслийг яаралтай эхлүүлэх шаардлагатай байна.

Ном зүй:

1. *Монгол Улсын Засгийн газрын Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр. 2017 он*
2. *Зайлсхийж болох сохрол,хараа сулралаас сэргийлэх,хянах стратеги 2014 он*
3. *Зайлсхийж болох сохролын түргэвчилсэн судалгааны тайлан 2015 он*
4. *Хүний төлөө хүчирхөг баг 80 товхимол - 2011 он*
5. *Д.Лхагвадолгор. Улсын Клиникийн Төв Эмнэлгийн Нүд Судлалын Клиникийн сүүлийн 10 жилийн үйл ажиллагааны тайлан. Нүд судлалын Монголын сэтгүүл 2008 он /3/ хуудас 34-36*
6. *Ж.Баттуяа,Т.Анара. П.Н.Шастины нэрэмжит Төв Эмнэлгийн Нүдний эмгэг судлалын тасгийн сүүлийн 10 жилийн үйл ажиллагааны тайлан. Нүд судлалын Монголын сэтгүүл 2008 он /3/ хуудас 32-34*

Study of the dynamics of eye disease on patients visited during 2016-2018

D.Batjargal[1], Sh.Myagmarsuren[2]

[1]Polyclinic department, Second State Central hospital
[2]Head of SDMTA, Second State Central hospital
E-mail: mrdbatjargal@gmail.com

Abstract: The reason for this study is the lack of research on eye diseases in the population and the lack of research to improve access to eye care. We have used the report of the Polyclinic Eye cabinet 2016-2018 and the reports of illnesses. Results show cataract is the most among the top 5 diseases, glaucoma is in the third place among the main causes of double blindness. In terms of morbidity, refractive changes increase from 30-44, lens and mucosal disorders and glaucoma are increased from 40-59 years of age. We concluded that it is necessary to introduce international standard treatment for cataract surgery, to establish a new cabinet for glaucoma prevention, to start visual care to correct vision loss caused by refractive errors that occur at a relatively young age. There is an urgent need to launch a project to establish an Eye Health Center at the Second State Central Hospital to address these issues in a comprehensive manner.

Keywords: Eye disease, cataract, glaucoma, vision loss